



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 03

Алтай

Улсын аварга тариаланчид
тодорхойлох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 202 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын аварга тариаланч” шалгаруулах журам, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Улсын аварга тариаланч” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлтийг хангасан Халиун сумын Сүүж багийн ногоочин Даваагийн Лхаажавын газар тариалангийн салбарт гаргасан ажлын амжилт, хөдөлмөрийг нь үнэлж Монгол улсын аварга тариаланчаар шагнуулахаар уламжилсугай.

2. Д.Лхаажавыг Улсын аварга тариаланчид тодорхойлсон материалыг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ